



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 05


Урт

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
шагналын төрөл, түүнийг олгох журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналын төрөл, түүнийг олгох журмыг хавсралтаар баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

493000001

Гурвантэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 25 тоот
тогтоолын хавсралт

ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ШАГНАЛЫН ТӨРӨЛ, ТҮҮНИЙГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Сумын хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтад бодитой хувь нэмэр оруулж, иргэдийн сайн сайхны төлөөх үйлсэд эрхэлсэн ажил хөдөлмөр, эрдэм мэдлэг, авъяас чадвараа дайчлан онцгой амжилт гаргасан Гурвантэс сумын иргэн аж ахуйн нэгж байгууллага, уугуул иргэнийг шагнаж урамшуулна.

Хоёр. Шагналын төрөл, олгох болзол

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шагнал нь дор дурдсан төрөлтэй байна.

2.1 Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт өргөмжлөл”, түүний болзол

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт өргөмжлөл”-өөр сум орон нутгийн хөгжил цэцэглэлтэнд бодитой хувь нэмэр оруулж, улс, аймаг, сумын нэр хүндийг өндөрт өргөж онцгой амжилт гаргасан иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг шагнана.

2.1.1 Орон нутгийн хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтад бодитой хувь нэмэр оруулсан байх

2.1.2 Сум орон нутгийнхаа нэр хүндийг аймаг, улс, олон улс, дэлхийн хэмжээнд цуурайтуулж урлаг, спортын төрлөөр өндөр амжилт гаргасан байх

2.1.3 Сумынхаа нийгэм, эдийн засаг, бизнесийн салбарт бодит хувь нэмэр оруулж шилдэг бүтээн байгуулалт хөрөнгө оруулалт хийж, ард иргэдийнхээ сайн сайхны төлөө олонд үнэлэгдэхүйц тодорхой зүйлийг хийсэн байх

2.1.4 “Хүндэт өргөмжлөл”-ийг 250 000 /Хоёр зуун тавин мянган/ төгрөгийн мөнгөн шагнал дагалдана.

2.2 Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын өргөмжлөл, түүний болзол

2.2.1. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын даргын өргөмжлөл шагналаар сумын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулж идэвх, зүтгэл гаргаж үр бүтээлтэй ажилласан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг тэмдэглэлт ой, баяр ёслолыг тохиолдуулан нэг удаад 3-аас дээшгүй хүнийг шагнана.

2.2.2. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын өргөмжлөлийг 40 000 /дөчин мянган/ төгрөгийн мөнгөн шагнал дагалдана.

Гурав. Шагналын тоо

3. Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шагналыг дор дурдсан хязгаарын дотор олгоно.

3.1 Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт өргөмжлөл”-ийг жилд нэг хүнд

3.2 Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын өргөмжлөлийг жилд 10 /арав/ хүртэл хүнд

Дөрөв. Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох

4. Шагналд нэр дэвшүүлэх хүсэлтийг тухайн хүний ажиллаж суралцдаг байгууллага, хамт олон, багийн Засаг дарга гаргаж дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна.

4.1 Тухайн байгууллагын хүсэлт

4.2 Нэр дэвшигчийн анкет /анкетанд нэр дэвшигчийн овог нэр, хүйс, регистрийн дугаар, төрсөн огноо, төрсөн газар, боловсрол, мэргэжил, урьд болон одоо эрхэлж байгаа ажил, шагнуулах үндэслэл, холбоо барих утсыг тодорхой тусгаж цээж зураг наасан байна. /

4.3 Хамт олны хурлын тэмдэглэл

4.4 Ажил байдлын тодорхойлолт, сүүлийн 3-5 жилийн ажлын үзүүлэлт

4.5 Дээрх материалуудыг шагнал гардуулахаас 7-оос доошгүй өдрийн өмнө сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд ирүүлсэн байна.

Тав. Шагнуулах хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх

5.1 Энэ журмын 3.1-д заасан шагналыг жил бүрийн сар шинийн баярыг тохиолдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид шийдвэрлэнэ.

5.2 Энэ журмын 3.2-д заасан шагналыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тухайн хүний шагнуулахаар ирүүлсэн тодорхойлолтод заасан амжилтыг үндэслэн шагнана.

___оОо___



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 06

Урт

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
шагналаар шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.15 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 05 тоот тогтоолоор батлагдсан “Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналын төрөл, түүнийг олгох журам”-ыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Тус сумын Урт багийн иргэн Мөнхчулууны Баярболдыг 2019 онд Шагайн спортын Монгол улсын мэргэн цол хүртсэн амжилтыг үнэлж сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт өргөмжлөл”-өөр шагнасугай.

2. Дээрх шагналын дагалдах мөнгөн шагнал 250 000 /Хоёр зуун тавин мянган/ төгрөгийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын нөөц сангийн зардлаас олгохыг нягтлан бодогч /Ө.Сувданшүр/-д зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

493000011



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 07

Урт

Сонгуулийн хэсэг байгуулж нутаг дэвсгэр,
төвийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.5, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулиар сонгогчдын санал авах, тоолох хэсгүүдийг Гоёт, Баясах, Тост, Урт, Бага-Овоо нэртэй байгуулж нутаг дэвсгэр, төвийг хавсралтаар баталсугай.
2. Хэсгийн нутаг дэвсгэр, төвийг иргэдэд мэдээлж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.
3. Уг тогтоолыг холбогдох газарт уламжлахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /П.Одончимэг/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

463000009



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 08

Урт

Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах
иргэнийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Дэлгэрмаагийн саналыг хэлэлцээд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. 2020-2022 онд Цэргийн албыг дүйцүүлэн хаах хүсэлт ирүүлсэн Урт багийн иргэн Наранбаатарын Мягмар /КГ98010611/ -ын саналыг дэмжсүгэй.

2. Энэ тогтоолыг холбогдох материалын хамт аймгийн Засаг даргад хүргүүлэхийг сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Ц.Дэлгэрмаа/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

493100008

Гурвантэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны ~~...~~ тоот
тогтоолын хавсралт

Монгол улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулиар
сонгогчдын санал авах, тоолох хэсгүүдийн
төв, нутаг дэвсгэр

№	Хэсгийн нэр	Хэсгийн төв	Хэсгийн нутаг дэвсгэр
1	Гоёот	ЕБС-ийн спортын шинэ заал	Гоёот багийн нутаг дэвсгэр
2	Баясах	Хуучин Соёлын төв	Баясах багийн нутаг дэвсгэр
3	Тост	Шинэ Соёлын төв	Тост багийн нутаг дэвсгэр
4	Урт	Хүүхэд залуучуудын Спорт цогцолбор	Урт багийн нутаг дэвсгэр
6	Бага-Овоо	Бага-Овоо багийн төв	Бага-Овоо багийн нутаг дэвсгэр

___оОо___